

Эмчлүүлэгчид өдрийн эмчилгээ үйлчилгээ үзүүлэх журам



**ЭМЧЛҮҮЛЭГЧИД ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ,
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Хувилбарын дугаар: 01

Хүчин төгөлдөр болсон огноо: 2023-07-05

Баримт бичгийн дугаар

Баримт бичгийг хариуцах нэгж			
Баримт бичгийн нууцлалын зэрэглэл:	Дотоод	Баримт бичгийн түвшин	2
		Албан тушаал	Гарын үсэг
Боловсруулсан:	ЗАХИРГАА УДИРДЛАГА	ЭЭДЗахирал -Д.Болормаа Чанарын менежер - Ж.Нарантуяа	<i>[Signature]</i>
Санал өгсөн:	ПОЛИКЛИНИК ЭТҮЧАБА	Албаны дарга Д.Цэцэгтуяа Албаны дарга Д.Лувсандамдин	<i>[Signature]</i>
Хянаж батласан:		Захирал: Г.Дашжанцан	<i>[Signature]</i>



Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл

Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлтийг батласан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсонг товч тайлбарлана)
1			Баримт бичгийн анхны хувилбар
2			
3			

АГУУЛГА

1. ЗОРИЛГО
2. ХАМРАХ ХҮРЭЭ
3. НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГ, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД
 - 3.1 Нэр томьёо
 - 3.2 Товчилсон үг
 - 3.3 Иш татсан баримт бичгүүд
4. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ЭРХ МЭДЭЛ
5. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЗАРЧИМ
6. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭМЧ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА
 - 6.1 Төрөлжсөн мэргэжлийн эмч нарын үүрэг хариуцлага
 - 6.2 Тасгийн эрхлэгчийн үүрэг хариуцлага
 - 6.3 Өдрийн эмчилгээ үйлчилгээний нэгж хариуцсан эмчийн үүрэг хариуцлага
 - 6.4 ӨЭҮнэгжийн сувилагчийн хүлээх үүрэг, хариуцлага 11
7. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖИД ЭМЧЛЭХ ЗААЛТ
8. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНД ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАХГҮЙ ЗААЛТ
9. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ
10. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖИД ЭМЧЛҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА
11. ХАРИУЦЛАГА
12. ХАВСРАЛТ

НЭГ. ЗОРИЛГО:

1.1 Өдрийн эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах

1.2 Эмнэлгийн шаардлагагүй хэвтэлт, орны хүлээгдлийг бууруулах

1.3 Эмч эмнэлгийн мэргэжилтний ажил үүрэг хариуцлага, сахилга дэг журам, тасаг нэгжийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулахад оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ:

БОЭТөвийн нийт эмч эмнэлгийн мэргэжилтэн, ӨЭҮНэгжийн эмч мэргэжилтэн дагаж мөрдөнө.

ГУРАВ. НЭР ТОМЪЁО, ТОВЧИЛСОН ҮГС, ИШ ТАТСАН БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

3.1 НЭР ТОМЪЁО:

- Өдрийн эмчилгээ: Үйлчлүүлэгчийг эмнэлэгт хонуулахгүйгээр үзүүлэх мэс заслын болон мэс заслын бус эмнэлгийн тусламж үйлчилгээ
- Өдрийн эмчилгээ үйлчилгээний нэгжийн эмч: Хуваарьт хугацаанд өдрийн эмчилгээ үйлчилгээний нэгжид ажиллан эмчлүүлэгчид өдөр тутмын үзлэг эмчилгээ хийж хяналт тавьж буй эмч
- Өдрийн эмчилгээ үйлчилгээний нэгжийн сувилагч: Хуваарьт хугацаанд өдрийн эмчилгээ үйлчилгээний нэгжид ажиллан эмчлүүлэгчид тутмын эмчилгээг хийж хяналт тавьж буй сувилагч
- Эмчлэгч эмч : Эмнэлгийн тусламж авсан өвчтөнг хамгийн олон цаг эмчилсэн эмчийг
- Өвчний түүх : Эмнэлэгт хэвтэн үйлчлүүлэгчдэд хийгдэж буй оношилгоо, эмчилгээний явц, үр дүнг тусгасан БОЭТөвийн нууцийн зэрэгт хамаарах хуулийн, сургалт эрдэм шинжилгээний баримт бичиг
- Хамтарсан үзлэг, зөвөлгөөн : Нэг мэргэжлийн болон өөр бусад нарийн мэргэжлийн нэгээс дээш эмч нар оролцон тухайлсан нэг эмчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээ оношилгооны асуудлаар хэлэлцэн дүгнэлт шийдвэр гаргахыг
- Тойрон үзлэг: Тасгийн нийт эмч, резиденс эмч, сувилахуйн мэргэжилтнүүд тасгийн бүх эмчлүүлэгчдийн биеийн байдал, шинжилгээ оношилгоо, эмчилгээний байдалтай богино хугацаанд танилцан шаардлагатай санал дүгнэлт гаргах
- Тусгаарлах (Isolation): Үйлчлүүлэгчийг тусгай өрөөнд бусад үйлчлүүлэгчээс тусгаарлан байршуулах халдвараас сэргийлэх үйл явц
- Магадлагаа гаргах: Хүн өвчлөх, осол, гэмтэлд өртөх, нас барах, төрөх, хиймэл эрхтэн хийлгэх, сувилуулах, хөл хоригдох, өвчтөн асрах гэм мэтэд нотолгоо гаргах
- Эмнэлэгээс гаргах: Эмчилгээг дуусган гэртээ гарах

3.2 ТОВЧИЛСОН ҮГС:

- ӨЭҮН-Өдрийн эмчилгээ үйлчилгээний нэгж
- “Code Blue”- Эмнэлгийн бүсэд өвчтөний амьсгал, зүрх судасны үйл ажиллагаа зогссон үед яаралтай үйлдэгдэх дохиоллын систем юм.
- Дефибрилятор – цахилгаан туйлшруулагч аппарат
- ЭСҮ- Эрт сэрэмжлүүлэх үнэлгээ

- БОЭТ- Бүсийн оношилгоо эмчилгээний төв
- ЭЭДЗ-Эмчилгээ эрхэлсэн дэд захирал
- ХСХ- Халдварын сэргийлэлт хяналт
- ЭТҮХХ- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар
- ААЗ- Аюулгүй ажиллагааны зааварчилгаа
- СМА-Статистик мэдээллийн алба

3.3 Холбогдолтой буюу иш татсан баримтжуулсан мэдээлэл

Эрүүл мэндийн тухай хууль

- Эмнэлгийн тусламжийн тухай хууль
- ISO 9001:2015 ЧУТ-ны стандарт
- Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS 5095:2017 стандарт
- Эрүүл мэндийн байгуулгын орчны эрүүл ахуйн шаардлага MNS 5991:2009
- Оношлогоо эмчилгээ түгээмэл үйлдлүүд MNS 4621:2008
- Эрүүл мэндийн сайдын тушаал 406 2019
- ЭМС-ын 2015 оны 12 сарын 11 өдрийн 483 тоот тушаал “Журам батлах тухай”
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тоот тушаал
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/537,538,539 тоот тушаал
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны 06 сарын 21 ны А/293
- Эрүүл мэндийн сайдын 2018 оны 505тоот хог хаягдлын менежмент
- БОЭТөвийн захирлын 2020 оны Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах нийтлэг журам

ДӨРӨВ. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА (RACI матриц)

Хүснэгт1- Процессын үүрэг хариуцлагын матриц

Процесс	Мэргэжлийн эмч нар	Хяръяа Тасгийн эрхлэгч	Цахим бүртгэл	ӨЭҮНэгжийн эмч	ӨЭҮН-ийн Сувилагч, Мэс засал,уламжлалт	Төрөлжсөн мэргэжлийн сувилагч .бага эмч	ӨЭҮН сувилагч	Даатгалын эмч	ЭТҮЧАБА
Эмчлүүлэгчийг ӨЭҮН-д хэвтүүлэх заалтыг гарган хүсэлт илгээх	RA	RA		C	C			-	-
ӨЭҮНэгжид эмчлүүлэх зөвшөөрөл олгох	I	RA		I	I			I	I
Өвчтний цахим түүх нээх	I	I	RA	I					
Эмчлүүлэгчид үзлэг хийн эмчилгээг төлөвлөн цахим түүхийг хөтлөх баталгаажуулах	RA	I		RA					
Мэс засал, мэс ажилбар, зүү төөнө гэх мэт төрөлжсөн мэргэжлийн эмчийн тусламж үзүүлэх	RA	A			RA	RA			
Бүх төрлийн боолт шарх цэгцлэлт,бариа бумба, физик эмчилгээ зэрэг төрөлжсөн сувилахуй хийх					RA	RA			

Эмчлүүлэгчийн өдөр тутмын эмчилгээг хийж хяналт тавих цахим түүхийг хөтлөх баталгаажуулах					RA		RA		
Өвчтөнд шаардлагатай мэдээлэл зөвөлгөө өгөх			RA	RA			RA		
Чанар төлбөрийн хяналт хийх		RA						RA	RA

(R- гүйцэтгэх, A- хариуцах, C- хамтран ажиллах, I-мэдээлэлтэй байх)

ТАВ. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЗАРЧИМ :

5.1 Эмчлүүлэгч, түүний гэр бүлийн оролцоог дэмжсэн тусламж үзүүлж тэдний аюулгүй байдал, эрх ашиг, зан заншлыг хүндэтгэж, нууцыг хадгална.

5.2 Нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг ханган хүндрэлээс урьдчилан сэргийлж ажиллана.

5.3 Эмчлүүлэгчид хүмүүнлэг, энэрэнгүй эрчимт эмчилгээ тусламжийг тэгш, хүртээмжтэй үзүүлнэ.

ЗУРГАА. ЭМЧ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА:

6.1 БОЭТөвийн эмч нарын үүрэг хариуцлага

- БОЭТөвийн эмчлэх эрх бүхий эмч өдрийн эмчилгээний түүх нээн эмчлэгч эмчээр ажиллаж болох ба өвчтний эмнэл зүйн байдал, шинжилгээнд дүгнэлт хийн өдрийн эмчилгээний заалтыг гаргана.
- Өдрийн эмчилгээ үйлчилгээний нэгжид эмчлүүлэх цахим хүсэлт гаргах
- Өөрийн төрөлжсөн мэргэжлийн чиглэлээр эмчилгээ үйлчилгээ тусламж үзүүлэх, тутам үзлэг хяналт хийж эмчлэгч эмчээр ажиллах
- ӨЭҮ-ний нэгжийн эмчтэй хамтран ажиллах
- Түүхийг журмын дагуу хөтлөн хааж, чанар төлбөрийн хяналт хийлгэн СМА-д хүлээлгэж өгнө.
- Үйлчлүүлэгчийн амбулаторийн картанд өдрийн эмчилгээ хийлгэсэн, цаашид хэрэгжүүлэх эмчилгээний зөвөлгөөг дэлгэрэнгүй тэмдэглэл хийж баталгаажуулна.

6.2 Харъяа тасгийн эрхлэгчийн үүрэг хариуцлага

- Өдрийн эмчилгээний хүсэлтийг хянан заалтыг нягтлан хүсэлтийг батлах
- Эмчилгээний удирдамж стандартын мөрдөлтөнд чанар төлбөрийн хяналт

хийх зөвлөн туслах

- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.3 ӨЭҮНэгжийн эмчийн үүрэг хариуцлага

• ӨЭҮНэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, аюулгүй бэлэн байдалд тогтмол хяналт тавин үл тохирлыг тухай бүр залруулах арга хэмжээ авч ажиллана.

• ӨЭҮНэгжийн сувилагч, туслах сувилагч нарыг эмнэлзүйн удирдлагаар ханган үйл ажиллагаанд хяналт тавина.

• Эмчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд эмчилгээ үйлчилгээтэй холбоотой мэдээллийг өгнө.

• ЭТҮХХалдвар, эмийн гаж нөлөө, хүндрэл эрсдэлийг эрт илрүүлэх сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана.

• Шаардлагатай тохиолдолд өвчтөнийг илгээсэн амбулаторийн эмчтэй холбогдож мэдээлэл солилцож өвчтний асуудлыг шийдвэрлэнэ.

Тухайлбал: Эмийн гаж нөлөө, антибиотек үл тохирол, хэсэг газрын урвал хүндрэл, ЭСҮнэлгээнд илэрсэн хазайлт, шинжилгээний аюултай хариу гэх мэт

• Өөрийн мэргэжлийн чиглэлээр хүлээн авсан өвчтөний эмчлэгч эмчээр ажиллана.

• Түүхийг журмын дагуу хөтлөн хааж, чанар төлбөрийн хяналт хийлгэн СМА –д хүлээлгэж өгнө.

• Үйлчлүүлэгчийн амбулаторийн картанд өдрийн эмчилгээ хийлгэсэн, цаашид хэрэгжүүлэх эмчилгээний зөвөлгөөг дэлгэрэнгүй тэмдэглэл хийж баталгаажуулна.

- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

6.4 Сувилагчийн хүлээх үүрэг, хариуцлага:

• Төрөлжсөн мэргэжлийн сувилагч бага эмч нар нь мэргэжлийн чиглэлээр эмчлүүлэгчид шаардлагатай мэс заслын боолт шарх цэгцлэлт, жижиг мэс ажилбар, бариа бумба, физик эмчилгээ зэрэг төрөлжсөн сувилахуй хийх ба холбогдох АШББ бүрэн хөтлөх үүрэгтэй.

• ӨЭҮНэгжийн сувилагч нь хуваарийн дагуу ӨЭҮНэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

• Сувилахуйн тусламж, үйлчилгээг холбогдох журам стандартын дагуу чанартай шуурхай үзүүлнэ.

• Эмчийн бичсэн эмчилгээ, гаргацгүй, ойлгомжгүй байх, эмчлүүлэгчийн биеийн байдалд зовуурь илэрсэн үед эмчид мэдэгдэнэ.

- Үйлчлүүлэгчийн эмчилгээг гардан хийнэ

• Шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлын хангана.

• Эмнэлгийн тусгай хог хаягдлыг стандартын дагуу ангилан, устгаж баталгаажуулна.

- Аюулгүй тарилгын стандартыг чанд мөрдөн ажиллана.

- Өрөө тасалгааны эд аж ахуйн бүрэн бүтэн байдлыг хангана.

• Өдөр тутамд хийгдсэн эмчилгээг түүхэнд тэмдэглэн, гарын үсэг зурж баталгаажуулна.

- Эмчлүүлэгч болон түүний ар гэрийхэн, асран хамаалагч нартай эелдэг найрсаг харилцана.
- Хууль журам заагдсан бусад үүрэг хариуцлага

ДОЛОО. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНД ЭМЧЛЭХ ЗААЛТ

- 7.1 Өвчтөний онош эмнэлзүй болон шинжилгээгээр бүрэн батлагдсан байх
- 7.2 Өвчтөний өвчин эмгэг амь насанд аюул учруулахгүй байх
- 7.3 Өдрийн эмчилгээ үйлчилгээний дараа өвчтөн гэртээ харих бүрэн чадамжтай байх
- 7.4 Бага насны хүүхэд өндөр настан хөгжлийн бэрхшээлтэй иргэд эмчилгээний туршид байнгын асран хамгаалагчтай байх
- 7.5 Өвчтөн хэвтрийн дэглэм сахих заалтгүй байх
- 7.6 Өвчтөн 24 цагийн дотор эмнэлэгт давтан үзүүлэх, мэргэжлийн сувилахуйн тусламж шаардлагагүй байх
- 7.7 Тухайн өвчтөний нэг удаагийн өдрийн эмчилгээ 10 өдрөөс хэтрэхгүй, улиралд нэг удаагаас хэтрэхгүй байх
- 7.8 Өвчтөн болон асран хамгаалагч нь холбоо барих утастай байх

НАЙМ. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНД ЭМЧЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАХГҮЙ ЗААЛТ

- 8.1 Эмчийн бичсэн жороор гэрээр ууж хэрэглэх эм, хүүхдийн мэс засал, өвчний түүх нээх шаардлагагүй амбулаториор хийх жижиг мэс ажилбар нь өдрийн эмчилгээ үйлчилгээнд хамаарахгүй.
- 8.2 Дараах тохиолдолд өдрөөр хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд хамруулахгүйгээр бусад тохирох хэлбэрийг сонгон үйлчилнэ. Үүнд:
 - 8.2.1 Эмчийн хяналтанд 24 цаг байх шаардлагатай байх
- 8.3 Эмчилгээ үйлчилгээг өдөрт 1-с олон удаа буюу цагийн тариа хийлгэх шаардлагатай үед
- 8.4 Хэвтрийн дэглэм сахих шаардлагатай, өвчтөний биеийн байдал хүнд, өвчний явц хүндрэх тохиолдолд
- 8.5 Шөнийн цагаар дахидаг, хурц өвдөлт өгдөг өвчний үед
- 8.6 Амбулаториор боолт хийх, шарх цэвэрлэх, жижиг оёдол тавих
- 8.7 Эмчийн жороор эмийг гэртээ уух боломжтой, өвчтөний биеийн байдал хөнгөн бол хамрагдахгүй.

ЕС. ӨДРИЙН ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГЖИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 9.1 Өдрийн эмчилгээ үйлчилгээний нэгжийг эрүүл ахуйн шаардлага хангасан өрөө тасалгаа, тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөцтэйгээр зохион байгуулна.
- 9.2 Эмчлүүлэгчид унд хөнгөн зуушаар үйлчлэх, сургалт мэдээлэл авах боломжоор хангасан байх ба энэхүү үйлчилгээг ӨЭҮнэгжийн сувилагч хариуцна.

- 9.3 Өдрийн эмчилгээ, үйлчилгээг поликлиникийн эрхлэгч удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах ба харьяа тасгийн эрхлэгч, ЭТҮЧАБА, даатгалын эмч нар холбогдох хяналт тавина.
- 9.4 Өдрийн эмчилгээ үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагааг өдрийн эмчилгээ үйлчилгээний нэгжийн эмч зохион байгуулж биечлэн тайлагнана.
- 9.5 Эмчилгээ үйлчилгээний 1 удаад үргэлжлэх хугацаа нь 4 цагаас хэтрэхгүй байна.
- 9.6 Өдрийн эмчилгээний нэгжид боолт, жижиг мэс ажилбар, уламжлалт сэргээн засах засал, физик эмчилгээ, хэсэг газрын эмчилгээ, үтрээний эмчилгээ зэрэг тусгай орчин нөхцөл шаардлагатай эмчилгээг хийхгүй ба дээрх эмчилгээг харьяа тасаг хариуцна.
- 9.7 Эмчилгээний дараа өвчтний биеийн байдлыг асууж лавлах, зөвлөгөө өгөх, холбоо барихад зориулсан утас, цахим сүлжээгээр хангасан байна.
- 9.8 Өдрийн эмчилгээ үйлчилгээ нь хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд хамаарахгүй ба хоол, цагаан хэрэглэлээр хангахгүй.
- 9.9 Өдрөөр хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний давтамж 5 өдрөөс багагүй 10 өдрөөс хэтрэхгүй, улиралд 1-ээс илүүгүй байна.
- 9.10 Өдрийн мэс заслын тусламжийг үзүүлэхдээ мэс заслын тусламж үйлчилгээний журмыг баримтлан ажиллана
- 9.11 Эмчилгээнд хэрэглэгдэх эм хэрэгсэлийг эмчлүүлэгчээс гаргуулахыг хориглоно.
- 9.12 Зайлшгүй шаардлагатай тохиолдол бүрт эмчлүүлэгчээс зөвшөөрлийн хуудсыг авч баталгаажуулна.
- 9.13 ЭТҮХХалдвараа урьдчилан сэргийлэх дэглэмийг чанд баримтална
- 9.14 Амилуулах, лавшруулсан тусламж үзүүлэх “code blue” журмыг хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангасан байна.
- 9.15 Хэрэв эмчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнд шилжих шаардлагатай үед өдрийн эмчилгээний түүхийг хааж, харьяа станционарын тусламжид шилжүүлж болно.

АРАВ. ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН БАРИМТЛАХ ЖУРАМ

- 10.1 Эрүүл мэндийн даатгалын хураамжаа сүүлийн 3 жилээр төлсөн байна.
- 10.2 Эмчилгээний заавар зөвөлгөөг чанд баримтлана.
- 10.3 Эмчилгээний цагийг товлон хоцрохгүй, таслахгүй хийлгэнэ.
- 10.4 Хувийн ариун цэврийг зохих ёсоор сахисан байна.
- 10.5 Эмч мэргэжилтэнд эмчилгээ үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтээ зөв боловсон тавиж хамтран шийдвэрлэх.

АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА

Энэхүү журмыг зохих ёсоор биелүүлээгүй эмч эмнэлгийн мэргэжилтэнд дотоод журмын дагуу хариуцлага хүлээнэ.

ӨЭҮН-ийн яаралтай тусламжийн эм тарианы жагсаалт

№	Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил	Тун хэмжээ	Хэмжих нэгж/хэлбэр	Доод хэмжээ
1.Бактерийн эсрэг/ антибиотууд /				
1	Цефазолин	1гр	фл	10
2	Гентамицин	80мг/2 мл	амп	10
3	Метронидазол	100мл	фл	10
2.Эпилепсийн эсрэг хэрэглэх бэлдмэл				
4	Карбамазепин	200мг	шах	10
3. Хэсгийн мэдээгүйжүүлэх бэлдмэл				
5	Лидокайн	2%-2мл	ам	10
6	Новокайн	0,25%-100мл	фл	2
4.Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих				
7	Эпинефрин	0,1%-1мл	ам	20
8	Допамин	0,5%-5мл	ам	5
10	Амиодарон	150мг/3мл	ам	10
11	Атропин сульфат	0,1%-1мл	ам	5
12	Панангин	10мл	ам	5
13	Карведилол	6.25мг,	шах	10
14	Лансорбид	5мг, 10мг	шах	10
15	Атенолол	50мг	шах	10
16	Бисопролол	5мг, 10мг	шах	10
17	Нитроглицерин	0,5мг	фл	1
5.Цусны даралт бууруулах				
18	Эналаприл	1,25мг/1мл	ам	10
19	Никардипин	1мг/10 мл	ам	5
20	Эналаприл	5мг/10мг	шах	10
21	Амлодипин	5мг/10мг	шах	10

Эмчлүүлэгчид өдрийн эмчилгээ үйлчилгээ үзүүлэх журам

22	Нифедипин	10мг/20мг	шах	10
23	Экватор	5/10мг 10/20мг	шах	10
24	Лозартан+гипотиазид	100/25	шах	10
25	Валсартан	160мг	шах	10
6.Гуурсан хоолойн агчлын үед хэрэглэх				
26	Аминофиллин	2,4мг/ам-10мл	ам	5
27	Сальбутамол		фл	1
7.Харшлын ба анафилаксийн эсрэг				
28	Преднизолон	30мг-1мл	ам	3
29	Дексаметазон	4мг/1мл	ам	10
30	Дифенгидрамин /димедрол/	1%-1мл	ам	10
31	Кетотифен	1мг	Шах	10
8.Өвдөлт намдаах, халуун бууруулах				
32	Метамизол натри	50%-2мл	ам	10
33	Ревалгин	5мл	ам	5
34	Диклофенак натри	50мг-3мл	ам	10
35	Кетопрофен	100мг/2мл	ам	10
9.Цусны бүлэгнэлтэнд нөлөөлөх				
36	Аминокапроны хүчил	5%-100мл	фл	5
37	Транексамын хүчил	50мг/5мл	ам	10
38	Дицинон	125мг/2мл	ам	5
39	Фитоменадион	0,1%-1мл	ам	5
10.Цусны бүлэгнэлтийн эсрэг				
40	Гепарин	5000ед-1мл	фл	10
41	Ацетилсалицилийн хүчил	100мг	фл	1
42	Клопидогрел	75 мг	таб	10
11.Эрдэс зохицуулах				

Эмчлүүлэгчид өдрийн эмчилгээ үйлчилгээ үзүүлэх журам

43	Кальцийн хлорид	10%-10мл	ам	5
44	Калийн хлорид	7,5%-100мл	фл	2
45	Магнийн сульфат	25%-10мл	ам	6
12.Бөөр шээсний замд нөлөөлөх/ шээлгэх эм, тариа/				
46	Фуросемид	1%-2мл	ам	10
47	Спиринолактон	25мг	шах	10
48	Гидрохлортиазид	25мг	шах	10
13.Шингэнүүд				
49	Натрийн хлорид	0.9%-100мл	фл	10
50	Натрийн хлорид	0.9%-500мл	фл	10
51	Плазм -лит	1000мл	фл	5
52	Рингерийн уусмал	250мл	фл	5
53	Рингерийн уусмал	500мл	фл	5
54	Глюкоз	5%-500мл	фл	3
55	Глюкоз	40%-40мл	ам	10
56	Глюкоз	5%-250мл	фл	3
57	Глюкоз	5%-100мл	фл	3
58	Глюкоз	20%-100 мл	фл	3
59	Маннитол	10%-100мл	фл	5
60	Маннитол	10%-250мл	фл	5
14.Бөөлжилтийн эсрэг				
61	Метоклопрамид	0,5%-2мл	ам	10
62	Метоклопрамид	10мг	шах	10
15.Агчил тавиулах				
63	Дротаверин	2%-2мл	ам	10
16.Витаминууд				
64	Аскорбины хүчил	5%-2мл	ам	10

65	Тиамин бромид	1мл	ам	20
17.Сахар бууруулах				
66	Актропид	100 ед	фл	1
67	Инсултрад	100 ед	фл	1
18.Мансууруулах, сэтгэц нөлөөт эм, тариа				
68	Морфин гидрохлорид	10мг/мл-1мл	ам	3
69	Диазепам	10мг-2мл	ам	10
70	Трамадол	50мг/1мл	ам	3
19.Нэг удаагийн хэрэгсэл				
71	Эмнэлгийн вазелин	20гр	тюб	1
72	Уян бинт /өргөн, нарийн/		ш	12
73	Бинт		ш	5
74	Чангалуур		ш	2
75	Катетр		ш	10
76	Шээсний уут		ш	10
77	Шээсний сав		ш	10
78	Дуслын систем		ш	10
79	Нугасны хатгалтын зүү /22G, 20G/	Нэг удаагийн	ш	5
80	Тариур	1гр	ш	5
81	Тариур	3гр	ш	10
82	Тариур	5гр	ш	10
83	Тариур	10гр	ш	10
84	Тариур	20гр	ш	10
85	Уян зүү	18G	ш	10
86	Уян зүү	20G	ш	10
87	Уян зүү	22G	ш	10
88	Уян зүү	24G	ш	10

89	вакумтеннер /зүүтэй/	Нэг удаагийн	ш	10
90	Мэс заслын утас №3,0 гурвалжин зүү	Нэг удаагийн	ш	12
91	Мэс заслын хутганы ир /8,10,12/	Нэг удаагийн	ш	10
92	Мэс заслын бээлий	Нэг удаагийн	ш	10
93	Ходоодны зонд №-18,16	Нэг удаагийн	ш	10
94	Электрод	Нэг удаагийн	ш	10
95	Бээлий	Нэг удаагийн	ш	100
96	Хүчилтөрөгчийн маск	Нэг удаагийн	ш	10
97	Хүчилтөрөгчийн хамрын гуурс	Нэг удаагийн	ш	10
98	Утлагын гуурс	Нэг удаагийн	ш	5
99	Амьсгалын хүрээ гуурс	Нэг удаагийн	ш	10
100	Фильтер	Нэг удаагийн	ш	10
101	Тамедин 7,5%	Нэг удаагийн	ш	3
102	Хлоргексидин уусмал -0,05%-100,0	Нэг удаагийн	ш	3
103	Төв венийн гуурс	Нэг удаагийн	ш	4
104	Малгай	Нэг удаагийн	Ш	20
105	Маск	Нэг удаагийн	Ш	20
106	N95 маск	Нэг удаагийн	Ш	10
107	Халад	Нэг удаагийн	ш	20

9.3 ӨЭҮНэгжийн тоног төхөөрөмжийн жагсаалт*/хавсралт -8/*

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Байх ёстой тоо ширхэг
1.	Эмчилгээний буйдан	8
3	Утлагын аппарат	2
4	Монитор	2
5	Дуслын памп	2
6	Шахуургын памп	2
8	Штатив	8
10	Яаралтай тэргэнцэр	1
11	Сувилагчийн тэргэнцэр	1
12	Дефибрилятор	1
	Хүчилтөрөгч өтгөрүүлэг	1
15	Даралтын аппарат	1
16	Биеийн дулаан хэмжигч	2
17	Чагнуур	1
18	Пульсоксиметр	1
19	Цусны глюкоз хэмжигч	1
20	Кварцын гэрэл	1
21	Хажуугийн гэрэл	1
22	Дэр	8
23	Хөнгөн хөнжил	8

Хийгдэх гардан үйлдлийн жагсаалт

№	Үйлдэл
1	Гар халдваргүйтгэх
2	Гар угаах
3	Бээлий өмсөх, тайлах
4	ХХХ өмсөх тайлах
10	Эмчлүүлэгчийн амин үзүүлэлтүүд үзэх арга техник
11	Эмчлүүлэгчийг тээвэрлэх
12	Эмчлүүлэгчид жин бигнүүр тавих
13	Эмчлүүлэгчийг мэс засалд бэлтгэх
14	Эмчлүүлэгчид уян зүү тавих арга техник
15	Эмчлүүлэгчид соруулга хийх
16	Эмчлүүлэгчид хүчилтөрөгч өгөх
17	Эмчлүүлэгчийн цусны бүлэг тодорхойлох цус сэлбэлт
18	Эмчлүүлэгчид цэвэрлэх бургуй тавих
19	Эмчлүүлэгчид шээлгүүр тавих арга техник
20	Арьсан дотор тарилга хийх арга техник
21	Арьсан дор тарилга хийх арга техник
22	Булчинд тарилга хийх арга техник
22	Судсанд тарилга хийх арга техник
23	Дуслаар шингэн сэлбэх арга техник
24	Ходоодны зонд тавих
25	Туншилээс эмийн бодис соруулж тарих арга техник
26	Флаконттой эмийг найруулж тариа хийх
27	Хэвлийн хөндийд гуурс хийх
28	Хэвлийн шингэн авах
29	Цээжний хөндийд хатгалт/ пункт/ хийх
30	Цээжний хөндийд гуурс хийх
31	Сэхээн амьдруулах лавшруулсан тусламж / цээж шахах, амьсгал амбугаар удирдах "CODE BLUE"
32	Кардиоверс, дефибрилляц
36	Төв венийн судсанд гуурс хийх

38	Өртөлтийн цомог ашиглах
39	Асгарсан цацагдсан биологийн шингэнийг цэвэрлэх
42	Халдварын эрсдэл багатай эд зүйлсийг халдваргүйтгэх
43	Хөтөвч суултуур халдваргүйжүүлэх

ХСХ-ын бэлэн байдлын цомог / хавсралт-5/

1. Өртөлтөөс сэргийлэх цомог

- Спирт 70%
- Шархны наалт
- Боолт самбай
- Цус тогтоох цацлага
- Гепатит В,С вирус ХДХВ илрүүлэх түргэвчилсэн тест, шинжилгээ авах хэрэгсэл байна.

- **Биологийн шингэнтэй харьцах иж бүрдлийн цомог**
- Нойтон шал тэмдэглэгээ
- Шар уут
- Ахуйн болон нэг удаагийн бээлий
- Амны хаалт
- Нэг удаагийн малгай
- Нүдний шил
- Жавелионы 0,03%ийн уусмал бэлтгэсэн
- Цаасан алчуур
- Хулдаасан хормогч
- Хогны шүүр
- Хогны хутгуур

ӨЭҮНэгжийн чанарын шалгуур үзүүлэлт

Дд	Шалгуур	2023 онд хүрэх түвшин
1	Дундаж ор хоног	7 хоног
2	Даатгалын хасагдал	0
3	ЭТҮХХалдварын хувь	0
4	Нотлогдсон гомдол	0
5	Ерөнхий сэтгэл ханамж сайн үзүүлэлтийн эзлэх хувь	95%
6	Өдрийн эмчилгээнээс тасагт шилжиж эмчлүүлсэн хувь	0
7	Нас баралт	0

9.1 Ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулж тооцно.

9.2 Ажлын байрыг эзэнгүй орхиж явахгүй ба эмчлүүлэгчийг оношлогоонд /ЭХО, Рентген г.м/ авч явах, эмчлүүлэгчийг өөр тасагт шилжүүлэх, эмийн сан, шинжилгээ хүргэх, хариуг авах гэж явах үед тасгийн эмч, сувилагчид аль нэгэнд захиж үлдээх, мэдэгдэх ёстой.

9.3 Журамд заасан заалтуудыг удаа дараа зөрчвөл тасгийн хурлаар хэлэлцэж шаардлагатай нөхцөлд ЭЭОЗ, Чанарын албанд мэдээлж шийдвэрлүүлнэ.

9.4 Үйлчлүүлэгч эмнэлгийн ажилчдыг ажил үүргээ гүйцэтгэж байхад санаатай болон санамсаргүй хохирол учруулахгүй байх.

9.5 Үйлчлүүлэгч энэхүү журмын 8.2 Заалтыг зөрчвөл ар гэрт нь мэдээлж 2 цагийн дотор ирээгүй тохиолдолд өвчтөний түүхийг хааж эмнэлэгийн тусламж үйлчилгээг зогсооно.

9.6 Үйлчлүүлэгч энэхүү журмын 8.3 заалтыг зөрчвөл баримтжуулж, холбогдох байгууллагад мэдээлж шийдвэрлүүлэх

Эмчийн бичсэн эмчилгээг дур мэдэн өөрчлөх, хийлгүй орхих, шинжилгээг дутуу өгөх, шинжилгээний хариуг авчрахгүй удах зэргийг хориглоно.